

**БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГАД НЭР ДЭВШҮҮЛЭХ ТУХАЙ АСУУДЛААР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХҮЙН БАЙНГЫН ХОРООНООС
ГАРСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2013 оны 12 дугаар
сарын 25 -ны өдөр

Улаанбаатар
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын
гишүүн Ц.Оюунгэрэл**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг тус Байнгын хороо 2013 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6., мөн хуулийн 22 дугаар зүйлийн 22.4., Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт заасныг баримтлан Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцлээ.


Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Гарьдхүүгийн Баярсайханыг улируулан ажиллуулахаар нэр дэвшүүлснийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Гарьдхүүгийн Баярсайханыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргаар сонгуулахаар нэр дэвшүүлсэн Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



БАЯРСАЙХАН